



ХЭНТИЙ АЙМАГ  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар A/227

Өмнөдэлгэр сум

Газар байршлыг өөрчлөх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дүгээр зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн A/01 дүгээр тогтоолын 13 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өмнөдэлгэр сумын Гурванбаян багийн нутаг дэвсгэр Баян гэх газарт худалдаа, нийтийн үйлчилгээний төв цогцолборын зориулалтаар Лхаасүрэнгийн Тунгалаг (ДН65031001) 15 жилийн хугацаатайгаар олгосон 0,5 га газрын байршлыг өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2.Газрын байршлыг өөрчилсөн кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэн, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гурванбаян багийн (Б.Энхтайван)-д үүрэг болгосугай.

4.Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээний дагуу эзэмшихийг газар эзэмшигч Л.Тунгалагт даалгасугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 04 сарын 30-ны өдрийн A/91 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.



R. ЭНХТАЙВАН

D:disk/bichig hereg/zahiramj

2224100464